

Улсын Дээд шүүхийн
Захиргааны хэргийн танхимд

2024.12.05

Хяналтын журмаар гомдол гаргах нь

“ЭЖ эрдэнэ майнинг” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ж.Сайнсанаа, Б.Одонтуяа нарт холбогдох захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 221/МА2024/0706 дугаар магадлалыг эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Гомдлын үндэслэл: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн

123.2.1.шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

123.2.4.эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой

Нэхэмжлэгчээс Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ж.Сайнсанаа, Б.Одонтуяа нарын тус компанид холбогдуулан гаргасан нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгуулахаар тухай нэхэмжлэл гаргасан.

Маргаан бүхий 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн НА-3524000001 дугаартай нөхөн ногдуулалтын актаар:

“ЭЖ эрдэнэ майнинг” ХХК-ийн 100 хувийн хувьцааг 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Компанийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-ний үндсэн дээр Ө.Баянмөнхөөс О.Түвшинбилэгт шилжүүлэхдээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль(2006 оны)-ийн 8 дугаар зүйлийн 8.2.2-д заасан (хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа бусдад шилжүүлэх замаар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон) орлогоос 17 дугаар зүйлийн 17.2-т заасан (30%) хувь хэмжээгээр суутган авч 21 дүгээр зүйлийн 21.5-д заасан (ажлын 7 хоногийн дотор буюу 2019 оны 04 дүгээр сарын 19-ний дотор) хугацаанд татварыг суутган авч төсөвт төлөхөөр заасныг зөрчсөн гэж 250,000,000 төгрөгийн зөрчилд 75,000,000 төгрөгийн нөхөн татвар, 22,500,000 төгрөгийн торгууль, 15,000,000 төгрөгийн алданги, нийт 112,500,000 төгрөгийн төлбөр төлүүлэхээр шийдвэрлэсэн.

1. Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д “албан татвар” гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг” ойлгохоор заажээ.

Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 103/ШШ2024/00363 дугаартай “Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” захирамжаар “Ө.Баянмөнхийн нэхэмжлэлтэй, О.Түвшинбилэгт холбогдох “компанийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээг цуцалж, “Эж эрдэнэ майнинг” ХХК-ийн 187,713 ширхэг хувьцааг буцаан шилжүүлэхийг хариуцагчид даалгах” нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч хүлээн зөвшөөрснийг баталсан.

Иргэний хуулийн 205 дугаар зүйлийн 205.1-д “Хууль буюу гэрээнд заасны дагуу аль нэг тал нь гэрээнээс татгалзсан бол талууд гэрээний гүйцэтгэлийг биет байдлаар нь, түүнчлэн гэрээ биелсэнээс олсон ашгийг харилцан буцааж өгөх үүрэгтэй.” гэж заасан. Тодруулбал, гэрээнээс татгалзсанаар хүлээн авсан гэрээний гүйцэтгэлийг буцаан олгох буюу компанийн хувьцааны эзэмшигч статусын хувьд хэн аль нь гэрээ байгуулахаас өмнөх анхны байдалд очно.

Энэ тохиолдолд Ө.Баянмөнх О.Түвшинбилэгээс компанийн хувьцааг буцаан авч эрх зүйн байдлын хувьд 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнөхтэй ижил болсон тул дээрх хуулийн “...бусдад шилжүүлэх замаар...”, “...эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар” гэсэн үйлдлүүд хийгдээгүй, “...олсон орлого...” гэж байхгүй тул түүнд татвар ногдуулсан нь үндэслэлгүй болсон бөгөөд Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д заасан “шударга байх” зарчимд нийцэхгүй.

Хэрэв хариуцагч нарын шийдлээр тогтоовол Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг биелүүлэн компанийн хувьцааг буцаан шилжүүлэх үед дахин татвар төлөх бөгөөд энэ тохиолдолд компанийн хувьцаа анх байсан эзэмшигчийн өмчлөлд эргэн орохдоо 60/30+30/ хувийн татвар төлөх нөхцөл байдал үүсэхээр байна.


2. Давж заалдах шатны шүүхийн магадлалын Тогтоох хэсэгт 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Зөрчлийн тухай хуульд байхгүй 11.19 дүгээр зүйлийн 1.2 заалтыг баримтласан. Үүнээс гадна нөхөн ногдуулалтын актад Зөрчлийн тухай хуульд байхгүй 11.19 дүгээр зүйлийн 19.1.1.1 болон маргаанд хамааралгүй 74 дүгээр зүйлийн 74.1(татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн) үндэслэсэн тул хууль бус болно.

Түүнчлэн, нэхэмжлэгчийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль/2006 оны/-ийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасан “Энэ хуулийн 17.2.1-17.2.3, 17.2.7-17.2.9-д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ” гэж заасныг зөрчиж төсөвт төлөөгүй зөрчил гаргасан гэж үзвэл түүнд холбогдох хариуцлагыг хүлээлгэх буюу торгууль, алдангийг ногдуулах ба дээр дурдсаны дагуу татвар төлөх үндэслэлгүй, нөхөн татвар нь шийтгэл биш тул зөрчлийн хариуцлагад хамааруулахгүй болохыг давж заалдах шатны шүүхээс зааглаагүй шийдвэрлэсэн.

Мөн магадлалын Хянавал хэсгийн 3.3-т “нэхэмжлэгч хяналт шалгалтын үед тус гэрээний биелэлтийн дагуу тусгай зөвшөөрлийн эрхийг шилжүүлэн авсан болохоо хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр” гэж гэрээний үүргийг биелүүлсэн тухайд дүгнэсэн нь хүчин төгөлдөр шүүгчийн захирамжаар шийдвэрлэсэн асуудлыг шийдвэрлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-т заасныг зөрчсөн.

Иймд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 221/МА2024/0706 дугаар магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж өгнө үү.

- Шүүх хуралдаанд биечлэн оролцох тул товыг мэдэгдэнэ үү.
- Улсын тэмдэгтийн хураамж/70,200₮/ төлсөн баримтыг хавсаргав.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч  Б.Анхбаяр